

**ДЭЛХИЙН II ДАЙНЫ ҮЕИЙН МОНГОЛ, ЗӨВЛӨЛТИЙН
СОЁЛЫН ХАРИЛЦАА**

Ж.Болдбаатар, Д.Батбаяр
МУИС, Түүхийн судалгааны хүрээлэн

ӨГҮҮЛЛИЙН ТОВЧ УТГА: Дэлхийн II дайны үеийн Монгол, Зөвлөлтийн соёлын харилцааны үр дүнг МУИС байгуулахад соёл, шинжлэх ухаан, урлаг, утга зохиолыг хөгжүүлэхэд ЗХУ-аас үзүүлсэн тусламж зэргээр жишээ авч өгүүлсэн болой. Чингээд энэ харилцаа агуулгын хувьд гүн гүнзгий ах дүүс, интернациолын шинжтэй хэлбэрийн хувьд боловсрол, шинжлэх ухаан, соёл, утга зохиол, урлагын бүх салаа мөчрийг дүүрэн хамарсан хэмээх дүгнэлт хийсэн юм. Мөн соёлын харилцааг социалист үзэл сурталжуулж байсан болон дайны жилүүдийн нийгэм-сэтгэл зүйн сөрөг уур аймьсгалын тухай урьд өмнө бичигдэж байгаагүй аман түүхийн мэдээ оруулсан болно.

ТҮЛХҮҮР ҮГ: Соёл, боловсрол, дээд сургууль, их сургууль, оюутан, раборак, тусгай мэргэжлийн дунд сургууль, крилл үсэг, дайны фронт, өгүүлэл, найруулал, тэмдэглэл, театрын урлаг, кино, цирк, марксист-ленинист үзэл суртал, ангич байр суурь.

Энэхэн замбуулин дээр хүн төрөлхтөний нэг хэсэг нь бүтээж байхад нөгөө хэсэг нь нурааж устгаж байх жамтай ажээ. Европ, Азид дэлхийн хэмжээний их дайн дэгдэн, хүн төрөлхтөний соёлын гайхамшгийг устгаж байхад Монгол орон ЗХУ-ын тусламжтайгаар түүхэндээ хэзээ байгаагүй соёлын гайхамшгийг бүтээж байсныг түүх гэрчилнэ. Тухайн үеийн хөгжлийн шаардлагаар 1940 онд хуралдах МАХН-ын X их хурлаар улс орны соёлын хөгжлийн асуудал хэлэлцэхээр төлөвлөж байсан бөгөөд уг илтгэлийг МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Б.Баасанжав тавихаар бэлтгэж байсан юм. Гэвч тэрбээр их хурлын өмнөхөн улс төрийн хилс хэргээр баривчлагджээ. Гэсэн хэдий ч Х.Чойбалсан тус хуралд тавьсан МАХН-ын улс төрийн тайлан илтгэлдээ “БНМАУ-ын соёлын хөгжилтийн байдал ба зорилгууд” хэмээх тусгай бүлэг оруулан, “Хэрэв бид урагшаа дэвшихийг хүсэх аваас манай соёл боловсролыг хөгжүүлэх хэрэгт жинхэнэ хувьсгалыг хийх хэрэгтэй байна” /1, 55/ гэж тэмдэглэжээ. Тус их хурал “... Манай улсын ... хөгжил нь гагцхүү Зөвлөлт Холбоот Улсын аварга тусламж ... санаачлагын ач болно” /1,333/ гэж дүгнэжээ.

Энэхүү тусламж, ялангуяа хоёр орны соёлын хамтын ажиллагаа дайны жилүүдэд ч үнэхээр бахархан дурсмаар үргэлжилсэн юм. Ялангуяа тус улсын боловсролын хөгжилд ЗХУ-аас олон талын тусламж дэмжлэг үзүүлсээр байв.

1941 онд Нам, улсын төв сургуулийг МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын шинэ хүчний дээд сургууль болгон өөрчлөн байгуулж, бүрэн биш дээд боловсролтой нам улсын удирдах ажилтныг бэлтгэх болов. Тус сургууль сургалтын төлөвлөгөө,

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

хэрэглэгдэхүүнийг зөвлөлтийн загвараар бэлтгэж, гол гол хичээлийг зөвлөлтийн мэргэжилтнүүд зааж байлаа.

Намын шинэ хүчний дээд сургууль байгуулахад ЗХУ тусламж дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ манай нам, улсын удирдах ажилтны мэдлэг чадварыг дээшлүүлэхэд анхаарал халамж тавьж байв. Тухайлбал, 1943 оны VII сарын 1-нээс нээгдсэн ЗХУ-ын Холбооны Бүгд Найрамдах улсуудын Намын Төв Хороо, хязгаар, муж, хотын намын хороодын лекторуудыг бэлтгэх, давтан бэлтгэх 6 сарын курст манай хэсэг удирдах ажилтан, лекторуудыг суралцуулж байжээ. Эл курст академич Г.Ф.Александров, Б.Г.Греков, В.П.Волгин, С.В.Бахрушин, П.Н.Поспелов зэрэг нэрт эрдэмтэд хичээл зааж байсан аж.

Дайны жилүүд дэх хоёр орны соёлын харилцаа эрчимтэй хөгжиж байсны төвлөрсөн илэрхийлэл нь Монгол Улсад орчин цагийн ууган Их Сургуулийг байгуулсан явдал юм. 1940 оны XII сарын 6-нд БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөл мөн оны XII сарын 6-нд Улсын Их Сургуулийг зоотехник, багш, хүний эмчийн салбартайгаар Ардын гэгээрүүлэх яамны харъяанд байгуулахаар тогтжээ. /2,278-280/ Гэвч МУИС-ийг нээх бэлтгэл ажил 2 жил шахам үргэлжилсэн билээ.

Ардын гэгээрүүлэх яамны сайд Т.Машлай УИХ-ын бэлтгэл курс нээх, материаллаг баазыг бий болгох талаар шаргуу хөөцөлдөж, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн анхны төслийг яамныхаа зөвлөх Алексей Владимирович Русаковтай хамтран боловсруулж эхэлжээ. Тэд юуны өмнө, ЗСБНХУ-ын Ардын Комиссариат нарын Зөвлөлийн дэргэдэх Бүх холбоотын дээд сургуулийн хэргийг эрхлэх хорооны дарга С.П.Кафтановт хандаж тусламж иржээ. Тэрээр хүсэлтийг хүлээн авч ЗХУ-ын томоохон их сургуулиудад МУИС байгуулахад туслах даалгавар өгсөн байна. Удалгүй Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургууль, Москвагийн анагаах ухааны I дээд сургууль, Тимирязевийн нэрэмжит ХАА-н академи зэрэг сургуулиас сурах бичиг, ном зохиол, лабораторийн багаж төхөөрөмж бэлтгэн Монгол руу ачуулжээ.

Энэ тухай академич Н.Содном: Энэ үед Зөвлөлт, Германы дайн ид өрнөж байсан 1942 он байлаа. Москвагийн их дээд сургуулиуд Уралын нуруунаас зүүн тийш Дундад Ази руу нүүж, хичээл хаагдаж багш оюутан нь дайнд дайчлагдаж байв. Яг энэ үед Москвагийн их сургууль, Москвагийн анагахын дээд, Багшийн дээд, ХАА-н дээд сургуулиудаас олон мянган сурах бичиг, төхөөрөмж ирж байв. Хил хүртэл төмөр замаар, тэндээс Улаанбаатарт ачааны машинаар авчирдаг байв. Анхны оюутан бид тэр ирсэн авдар хайрцгийг зөөн авчирч, дээрх сургуулийн тамга тэмдэгтэй, дугаартай

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

ном сурахууд урьд хожим үзээгүй хачин чамин багаж хэрэгслийг гаргаж, өрөө тасалгаандаа дэлгэн өрж байж билээ (3.32) гэж дурсан тэмдэглэжээ. Түүнчлэн Москвагийн их дээд сургуулиудаас туршлагатай эрдэмтэн багш нарыг гэр бүлийн нь хамт шинэ тутам байгуулагдаж буй МУИС-д ажиллуулахаар илгээжээ. Тэдгээр эрдэмтэн багш нар Т.Машлай, А.В.Русаков нарын бэлтгэсэн ерөнхий төсөл дээр ажиллан, сургалтын төлөвлөгөө, хичээл бүрийн хөтөлбөрийг зөвлөлтийн сургуулиудын заавраар боловсруулан бэлтгэжээ.

1942 оны X сарын 5. Энэ өдөр Монголын соёл, боловсролын түүхэнд хэзээ ч үл мартагдах өдөр болсон юм. Учир нь Улаанбаатар дахь В.И.Лениний нэрэмжит клубт Монгол улсын их сургуулийн нээлтийн ёслолын хурал болов. Хурлын тэргүүлэгчдийн байранд тэр үеийн төр засаг, намын удирдагчид Х.Чойбалсан, Г.Бумцэнд, Ю.Цэдэнбал нарын хүмүүсийг гарч ирэхэд цугларагсад алга нижигнүүлэн ташиж угтжээ.

Хурлыг БНМАУ-ын Ардыг Гэгээрүүлэх яамны сайд, тус сургуулийн анхны захиралыг хавсран гүйцэтгэгч Т.Машлай нээж үг хэллээ. Тэрбээр хэлсэн үгэндээ Монгол улсын түүхэнд орчин цагийн анхны сургууль нээж байгаа нь үнэнхүү гайхамшигт үйл явдал болохыг тэмдэглээд, тус сургуулийн багш нар дээд мэргэжилтнийг бэлтгэх талаар нам, засгаас дэвшүүлэн тавьсан зорилтыг хэрэгжүүлэхэд бүх хүчээ дайчлан ажиллахаа илэрхийлжээ. Тус хурал дээр Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал нар хэлсэн үгэндээ дэлхийн II дайны хүнд нөхцөлд ЗХУ-ын тусламжтайгаар Монгол улсад анхны их сургууль нээгдэж байгаа явдлын түүхэн ач холбогдлыг онцлон тэмдэглэж, дээд боловсрол олохын тулд нөх их хичээл зүтгэл гаргаж, шантрашгүй суралцахыг оюутан залуучуудад хандаж зөвлөжээ.

• ЗСБНХУ-ын Ардын Комиссариат нарын Зөвлөлийн дэргэдэх Бүх холбоотын дээд сургуулийн хэргийг эрхлэх хорооны дарга С.П.Кафатанов Монголд анхны их сургууль нээгдэж байгаа явдалд баяр хүргэж ирүүлсэн цахилгаан утсандаа “Монголын соёл боолвсролын алив үүсвэр бүхэнд бид тусалсаар ирсэн бөгөөд цаашид ч туслахад бэлэн байна” гэдгээ илэрхийлээд “залуу их сургуульд анхны тусламж болгон шинжлэх ухааны өндөр мэргэжлийн 7 ажилтныг явуулсны дээр физик, хими, ургамал, амьтан судлал, мал үржүүллэгийн ухааны лабораторийн хэрэгслийг илгээв” /5/ гэжээ.

Нээлтийн ёслолын хурал дээр мал эмнэлэгийн I ангийн оюутан С.Сосорбарам МУИС-д элсэгчдийг төлөөлөн баяр хүргэн үг хэлж, сурч мэдэхийн төлөө бүх хүч чадлаа дайчлан ажиллахаа илэрхийлсэн байна.

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

Маргааш нь 1942 оны X сарын 6-нд 95 оюутан, 12 багштайгаар хичээлээ эхэлсэн байна (4,5). 1942-1943 оны хичээлийн жилд химийн ухааны дэд эрдэмтэн, доцент С.И.Хромов, физик-математикийн ухааны дэд эрдэмтэн, доцент А.Г.Шафигулин, биологийн ухааны дэд эрдэмтэн, доцент А.Г.Банников, мал эмнэлгийн ухааны дэд эрдэмтэн, доцент С.А.Кудряцев, анагаах ухааны дэд эрдэмтэн, доцент В.Н.Топольский, хэл шинжлэлийн ухааны доктор профессор Л.С.Каштанов, физик-математикийн ухааны дэд эрдэмтэн Г.И.Крылов зэрэг зөвлөлтийн нэртэй эрдэмтэн хичээл зааж байжээ. Тэд зөвхөн хичээл заах төдийгүй оюутан залуус, монголын нийт сэхээтнүүдэд эрдэм оюунд тэмүүлэхийн учир холбогдлыг ухамсарлуулан ойлгуулж, биеэрээ үлгэр дууриалал үзүүлж байв.

Машлай сайд Гэгээрлийн яамны өргөн цар хүрээтэй ажлыг хариуцахын хамт их сургуулийн сургалт, хүмүүжлийн ажилд онцгой анхаарал тавьж байв. Тэрбээр захиралын үүргийг гүйцэтгэж байгаагийн хувьд тус сургуулийн багш, ажилтныг томилох, халахаас эхлээд бүх тушаалыг гаргаж, заавар чиглэл өгч байлаа. Т.Машлай сургуулийн эрдмийн зөвлөлийг байгуулж, сургуулийн амьдралын тулгамдсан асуудлыг хэлэлцэж байв. Жишээ нь: 1943 оны I сарын 25-ны Эрдмийн зөвлөлийн хурлаар тус сургуулийн хичээлийн жилийн тэргүүн хагасын шалгалтын дүнгийн тухай сургалт эрхэлсэн анхны профессор С.А.Кудряшовын илтгэлийг хэлэлцжээ. Уг асуудлыг хэлэлцэж байх явцад сул дүнтэй суралцсан оюутнуудыг сургуулиас хасах асуудал тавигдахад Машлай сайд:

-Хичээлд тааруу оюутныг хасахгүй бэлтгэлд шилжүүлэх нь зүйтэй гээд багш нарыг чармайлт гарган ажиллахыг сануулж шаардсан байна. МУИС-ийг хичээлийн байр барих зураг, төслийг Зөвлөлтийн ууган барилгачид хийжээ.

МУИС-ийн хичээлийн байрыг барих газрыг эрж шилэхдээ хуучин "Зүүн хүрээ" хийдийн Шар орд хэмээх төв дуганы өмнөх талбайг сонгосон байна. Хийдийн урдуур явсан хэдэн гудамж байсан айлуудын сургааган хашаануудыг буулган, айлуудыг хотын зах руу нүүлгэжээ.

1944 оны I сарын 4-ний 12 цагт МУИС-ийн хичээлийн байрны суурь тавих ёслол болж, Ерөнхий сайд Х.Чойбалсан, МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал, Ардын гэгээрлийн яамны сайд Т.Машлай, Зөвлөлтийн элчин сайд И.А.Иванов нарын удирдах хүмүүс оролцон, эдүгээгийн төв байрны баруун хойд өнцгийн суурин дээр цай, хадаг, дурсгалын бичиг булж, барилгын суурийн анхны чулууг тавих ёслол үйлджээ.

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

Барилгын суурийг ухахад уул овоо шиг шороо гарчээ. Тэр үед машин механизм ховор байсан учир үхэр болон морин тэргээр шороо зөөж байлаа. Засгийн газраас Тээврийн яаманд бүх хүчээ дайчлахыг үүрэг болгосон боловч хүчин мөхөсдөөр байв. Харин ЗХУ-аас БНМАУ-д суугаа элчин И.А.Иванов Машлай сайдад:

-Хотын бүх тэрэгчдийг хороо, хориноор бүртгэн авч, хүн бүрт их сургуулийн барилгын шороог хотоос гадагш гаргах, эсвэл хотын хотгор, гуу жалганд зам тэгшлэх тээврийн албан журмын үүрэг оноож, хэрэгжүүлэх боломжтой гэсэн мэргэн зөвлөгөөг өгчээ. Тэрхүү албан журмыг оногдуулахад монгол, хятадгүй хоёргүй хөдөлмөрлөж, чулуу шороог цэвэрлэжээ. Оюутнууд хичээлийн барилга дээрээ байн байн субботник хийнэ. Ингэж бүгд л эрвийх дэрвийхээрээ чин зүтгэл гаргасны үр дүнд хичээлийн байрны I ээлж болох баруун жигүүрийг барих ажил төлөвлөсөн ёсоор дуусчээ. МУИС 1944 оны X сарын 3-нд шинэ байрандаа нүүж орж, хичээллэх болсон байна.

Оюутнууд дайны хүнд үеийн гачигдал зовлонг амсаж байсан боловч сурч мэдэхийн төлөө залуу оюунаа дайчлан суралцаж байлаа. Тэр үед ЗХУ-аас уригдан ирсэн эрдэмтэн А.Г.Банников "Монголын залуучуудын эрдэм мэдлэг эзэмших гэсэн их хүслэн, ажилч хичээнгүй чанар, авъяас билэг нь биднийг цаг ямагт баярлуулж байлаа. Номын сан, тэнхим, сул тасалгаа, танхим бүрт шөнө дөл хүртэл ном уншиж суугаа оюутнууд харагддаг байв" (6,9) хэмээн өөрийнхөө дурьдатгалд дурсан тэмдэглэсэн байна.

Ийнхүү ажиллаж, суралцаж зав чөлөөгүй байтал хэд хэдэн хичээлийн жилийг ардаа орхисон байв.

Цаг хугацаа харвасан сум шиг өнгөрч, МУИС анхны төгсөлтийн босгон дээр тулж ирлээ. 1944 онд МУИС-ийн ректороор Б.Ширэндэв томилогдсон бөгөөд харин анхны төгсөлтийн Улсын шалгалтын комиссыг Ардын гэгээрлийн яамны сайд Т.Машлай толгойлсон юм. Улсын шалгалтанд Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал, зөвлөлтийн элчин И.А.Иванов нар биечлэн ирж сууж, төгсөх оюутнуудаас асуулт тавьж, зөвлөгөө өгч байлаа. Энэ нь тухайн үед нам, засгаас анхны их сургуулийн өрнөл, хөгжилд ихээхэн анхаарал тавьж байсны тод илрэл юм.

1946 оны VI сарын нарлаг сайхан өдөр Ленин клубт Чойбалсангийн нэрэмжит МУИС-ийн анхны төгсөлтийн ёслолийн хурал болов. Хуралд, юуны өмнө тус сургуулийн багш, оюутнууд, тэр тусмаа анхны төгсөгч 35 хүн нүүрний эгнээнд сууцгаажээ. Урилгаар оролцож буй төрийн яам, тусгай газрын сайд, дарга нар, албан үйлдвэрийн газрын дарга, даамал, хөдөлмөрийн сайчуул цөм суудлаа эзэлсэн байлаа.

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

БНМАУ-ын Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсан, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн дарга Г.Бумцэнд, МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал болон нам, засгийн бусад удирдагчид хурлын тэргүүлэгчдийн байранд гарч ирэхэд цугларагсад суудлаасаа босч, алга нижигнүүлэн ташиж угтав.

Хурлыг МУИС-ийн анхны төгсөлтийн улсын комиссын дарга, Ардын Гэгээрлийн Яамны сайд Т.Машлай удирдан, төгсөлтийн дүнгийн тухай товч илтгэж Машлай сайд төгсөгчдийн нэрийг өндөр дуугаар уншин дуудахад, төгсөгчид хурлын тэргүүлэгчдийн байранд гарч нам, засгийн удирдагчдаас дипломоо гардан авч байлаа. Цэргийн үлээвэр хөгжим нижигнэн, хүн бүхний сэтгэл догдолж байв.

МУИС-ийн анхны төгсөгч, хожим тус сургуулийн ректороор олон жил ажилласан академич Н.Содном: "Сайд Машлай бол МУИС-ийн дотоод ажлын бүх тушаалыг өөрийн гараар боловсруулан гаргаж байв. Сургалтын төлөвлөгөөг батлах, анги, тэнхмийг байгуулах, анхны гурван факультетийг бүрэлдүүлэн нээх, Зөвлөлтөөс ирсэн багш нарыг ажилд томилон, цалин хэрэгсэл олгох зэрэг бүх асуудал Машлай сайдын гараар орж, түүний тушаалаар гүйцэтгэж байв. Энэ явдал 1944 он хүртэл үргэлжилж, МУИС-ийн ажил жигдэрч ирсэн юмаа. Ийнхүү Гэгээрлийн яамны сайд Т.Машлай МУИС-ийг анхнаас нь эхлээд гардан зүтгэсэн гавъяат зүтгэлтэн юм. Хоосон нэр, цолыг бишрэн дагахгүй, ажлын авъяас, зүтгэлийг голлон харгалздаг сайн цаг байжээ. Ингээд МУИС бүрэн байгуулагджээ" (3,45-46) хэмээжээ. Иймд Т.Машлай бол зөвлөлтийн эрдэмтэн мэргэдэд түшиглэн улаан гараараа, ухаан санаагаараа МУИС-ийг үндэслэн байгуулсан гавъяат зүтгэлтэн бүлгээ.

ЗХУ манай оронд ууган их сургууль байгуулахад гараа сунгасан төдийгүй үүсэн хөгжиж байсан тусгай мэргэжлийн дунд сургуулиудын материаллаг баазыг бэхжүүлэх, шинээр сургууль байгуулах хэрэгт бодитой тусламж үзүүлсээр байв. 1940 оны IX сард Хиагтын багшийн сургуулийн монгол салбарыг Улаан-Үдийн монгол рабфакт нийлүүлж, улмаар тус рабфакийг 1941 оны VII сараас Улаанбаатар хотноо шилжүүлэн багшийн сургуультай нэгтгэжээ. Монгол рабфакийн хичээлийн бүхий л тоног төхөөрөмж, кабинет, лаборатори, номын санг БНМАУ-ын 20 жилийн ойгоор Улаанбатырын багшийн сургуульд зөвлөлтийн талаас бэлэг болгон өгчээ. Эдгээр нь тус сургуулийг өргөтгөн бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болов (7,48).

Дэлхийн II дайны жилүүдэд тусгай мэргэжлийн хэд хэдэн шинэ сургууль, заримыг нь хөдөө орон нутагт байгуулсан билээ. 1944 онд Ховд, Цэцэрлэг хотод малын бага эмч нарыг бэлтгэх сургууль нээжээ. Мөн онд фабрик, заводын сургуулийг

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

уран дархны сургууль болгон өргөтгөн байгуулжээ. Эдгээр сургуулиудад зөвлөлтийн мэргэжилтнүүд ажиллаж, хичээлийн хэрэглэл, лабораторийн багаж төхөөрөмж, үзүүлэн таниулах материалаар тусалж байв.

Улс орныг батлан хамгаалах салбарт боловсон хүчин бэлтгэхийн тулд ЗХУ-ын цэргийн академи болон бусад сургуулиудад монголын залуучуудыг суралцуулахын зэрэгцээ 1943 оны X сараас Д.Сүхбаатарын нэрэмжит офицерийн сургуулийг байгуулж, ардын цэргийн дунд боловсролтой дарга нарыг бэлтгэх болсон юм.

Дэлхийн II дайны жилүүдэд ерөнхий боловсролын сургуулиуд тооны хувьд нэмэгдэж, дайны төгсгөл үеэс бага, дунд сургуулийн хичээлийн, программыг зөвлөлтийн сургуулиудын туршлагад тулгуурлан шинээр боловсруулах ажил эхэлжээ. Дайны жилүүдэд ЗХУ өөрсдөө дутагдаж гачигдаж байсан ч монголын шинэ тутам байгуулагдсан бүрэн болон бүрэн бус дунд сургуулиудад хичээлийн хэрэгсэл, лабораторийн төхөөрөмж нийлүүлсээр байсан юм.

БНМАУ-д шинжлэх ухааныг хөгжүүлэх үйл хэрэгт ЗХУ-аас тусалсаар байв. Шинжлэх ухааны хүрээлэнд 1940 онд химийн лаборатори, 1943 онд мал аж ахуйн кабинетийг байгуулжээ. Дайны эхний жилүүдэд шинжлэх ухааны салбар бүрийн сектор, тасгуудад зөвлөлтийн зөвлөх мэргэжилтэн ажиллаж байв. Үндэсний мэргэжилтэн цөөхөн байсан тэр үед тэд нар үнэхээрийн хэрэгцээтэй хүмүүс байлаа. 1940-өөд оны эхэн үед монголын хөдөө аж ахуйг судлах талаар ЗХУ-ын ШУА, БНМАУ-ын Шинжлэх ухааны хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан нэг чухал ажил бол хадлан бэлчээрийн экспедицийг манай оронд ажиллуулсан явдал юм. Тэрхүү экспедици 1940-1942 оны турш Дорноговь, Өмнөговь, Дундговь, Өвөрхангай аймгийн зарим нутагт маршрутын судалгаа явуулж, өвс ургамлыг шинжилсэн байна. Үүний үр дүнд А.А.Юнатов, И.А.Цацепкин зэрэг зөвлөлтийн эрдэмтэд монгол орны хадлан бэлчээрийн талаар практик ач холбогдолтой судалгаа хийж, говийн дорнод хэсгийн хадлан бэлчээрийн картыг боловсруулжээ. Мөн Дорнодын геологи хайгуулын экспедицийн нэг отрядын бааз дээр 1943 онд ховор ба өнгөт металлыг шинжлэх зөвлөлт, монголын тусгай экспедицийг байгуулсан бөгөөд энэ нь хожим хувь нийлүүлсэн "Совмонголметалл" нийгэмлэгийн суурь болсон байна.

Дайны жилүүдэд монголын зөвлөлтийн зохиолч, уран бүтээлчид монгол, зөвлөлтийн найрамдал, хамтын ажиллагааг уран сайхны аргаар дүрслэн үзүүлэхийг зорьж байлаа. Эх орны дайны үед зөвлөлтийн улаан армийн дайчдад бэлэг хүргэх монголын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд оролцон, дайны фронтод хүрэлцэн очсон

Д.Сэнгээгийн “Замын тэмдэглэл”, Ч.Лхамсүрэнгийн бичсэн ардын өшөө авагчдын эгнээнд орж гитлерийн эзлэн түрэмгийлэгчидтэй тэмцсэн “Саша” хэмээх бяцхан партизаны тухай өгүүллэг, зөвлөлтийн армид бэлэг хуримтлуулах хөдөлгөөн хөдөө орон нутагт хэрхэн өрнөж буйг үзүүлсэн Б.Ринчений “Говьчуул фронтынхонд”, С.Дашдооровын “Учрал” зэрэг олон өгүүллэг, найруулал нийтлэгджээ.

Ц.Дамдинсүрэн “Хоёулаа миний хүү” хэмээх өгүүллэгтээ монгол, зөвлөлтийн ард түмний найрамдал, хамтын хичээл зүтгэлийг өвөрмөц, сонирхолтой дүрслэн үзүүлжээ. Нэгэн эгэл жирийн монгол эх Халх голын байлдаанд шархадсан хүүгээ аварсан зөвлөлтийн цэргийг “Хоёулаа миний хүү” хэмээн хайр хүндэтгэл үзүүлж байгаагаар дүрсэлжээ.

Ч.Лодойдамбын “Малгайт чоно” хэмээх өгүүллэгийн баатар Дамдин хөндийн хөх чоныг тав харайлгалгүй гүйцдэг хурдан борлог морио огтхон ч харамлалгүй зөвлөлтийн армид бэлэглэж байгаа тухай өгүүлжээ. Түүнчлэн Ц.Уламбаярын “Баярын нулимс”, Б.Баастын “Захидал” зэрэгт 1945 оны чөлөөлөх дайны мөн чанар, монголын армийн интернационалч ариун үйлсийг дүрсэлжээ.

Дайны жилүүдэд монголын зохиолчид, орчуулагчид зөвлөлт, орос болон дэлхийн утга зохиолын шилдэг бүтээлийг монгол уншигчдад хүргэх талаар ихийг бүтээв. Зөвлөлтийн утга зохиолоос орчуулахад цэрэг эх оронч сэдэвтэй бүтээл томоохон байр суурь эзэлж байв... Л.Леоновын “Довтолгоо”, В.Василевскийн “Солонго” хэмээх бүтээл орчуулагдан нийтлэгджээ. Манай тогтмол хэвлэлүүдэд А.Толстой, К.Симонов, И.Эренбург, В.Вишневский, В.Гроссман, В.Иванов, П.Павленко, Ф.Панферов, Л.Первомайский зэрэг зохиолчдын зөвлөлтийн хүмүүсийн баатарлаг тэмцлийг харуулсан өгүүлэл, тэмдэглэл хэвлэгдсэн байна. Эдгээр бүтээлүүд нь монгол түмэнд фашизмын харгис хэрцгий шинжийг танин мэдүүлж, энх тайван, ардчилалын ялалтад итгэх найдвар итгэлийг төрүүлж байлаа. Дэлхийн II дайны эцэс гэхэд монголын уншигчид шинээр зөвлөлт, орос болон өрнөд Европын зохиолчдын сонгодог 200 гаруй бүтээлүүдийг төрөлх хэлээрээ унших бололцоотой болсон байна.

Дайны жилүүдэд театрын урлагийн салбарыг хөгжүүлэхэд зөвлөлтийн мэргэжилтнүүд ихээхэн хичээл зүтгэл гаргаж байлаа. 1941 онд “Шарай голын гурван хаан” хэмээх хөгжимт драмын жүжгийг Д.Намдаг туурвин, хөгжмийг Б.Дамдинсүрэн, Б.Смирнов нар хамтран бичиж, Н.Бельский тайз, хувцасны чимэглэлийг урлан, Г.Уварова найруулан тавьжээ. Мөн 1942 онд “Мандухай цэцэн хатан” жүжгийг Ц.Цэдэнжав, Б.Бааст нар туурвин, хөгжмийг мөнөөх Б.Смирнов, Б.Дамдинсүрэн нар

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

бичиж, тайз хувцасны зураг загварыг Н.Бельский, Л.Гаваа нар зурж урлан, А.Рабинович найруулсан байна.

Түүнчлэн 1942 онд Д.Нацагдоржийн зохиолоор Б.Дамдинсүрэн, Б.Смирнов нар хөгжмийг бичиж туурвисан “Учиртай гурван толгой” дуурь тайзнаа амилсан нь монголын хөгжмийн урлагийн хөгжилд гарсан шинэ үзэгдэл байсан юм.

Дайны жилүүдэд үндэсний жүжгээс гадна зөвлөлтийн жүжгүүдээс орчуулан тавих нь манай театрын үзвэрийн бодлогын нэг чухал хэсэг болж байв. Тухайлбал, театрын зөвлөх А.Рабинович, найруулагч Э.Оюун нар санаачлан Симоновын бичсэн “Орос хүмүүс” (1943), “Намайг хүлээ” /1944/, жүжгүүдийг орчуулж, театрынхаа урын санд оруулсан түүхтэй.

Дайны жилүүдэд зөвлөлтийн уран бүтээлчидтэй хамтран “Сүхбаатар” (1942), “Цогт тайж” (1945) зэрэг томоохон уран сайхны кино туурвисан нь олон түмнийг эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд чухал ач холбогдолтой болов. Мөн 1941 онд “БНМАУ-ын 20 жил”, “1942-1943 онд Улаан армид явуулсан 2-р бэлэглэлийн тухай”, “Улаан армид явуулсан 3-р бэлэглэлийн тухай”, “Хувьсалт Монгол” танкийн цувааг шилжүүлсэн нь”, 1944 онд “БНМАУ” зэрэг олон арван баримтат кино бүтээсэн байна.

Дайны жилүүдэд Монголд шинэ үүссэн циркийг бие дааж, хөл дээрээ босоход зөвлөлтийн мэргэжилтэн багш нар чухал үүрэг гүйцэтгэжээ. 1942 он гэхэд байнгын цирк бий болж, хот, хөдөөгийн олон мянган үзэгчдэд тоглолтоо үзүүлсэн байна. 1943 онд зөвлөлтийн зохиолчдын бүтээлээр “Манай гурав” хэмээх пантомим-циркчилсэн жүжгийг Октябрийн хувьсгалын ойгоор зөвлөлтийн найруулагч А.Ширай найруулгаар улсын циркт тавьсан байна.

• Монголын циркийн жүжигчид 1942 онд ЗХУ-д очиж, 1943 онд Зөвлөлт Социалист Автономит Буриад Улсын хөгжимт драмын театрын жүжигчид БНМАУ-д хүрэлцэн ирж тогложээ. Улсын циркийг үндэслэн байгуулагч Ж.Раднаабазар “Бурятын үнэн” сонинд бичихдээ: “зөвлөлтийн үзэгчидтэй уулзсан уулзалт, тэдгээрийн халуун дотно хүлээн авалт, манай урлаг, ард түмнийг хайрладаг чин сэтгэлийн хайр нь манай циркийн хамт олон болон миний ажилд баяртай үр дүн авчирч, монголын циркийг улам өндөрт хөгжүүлэхэд бидэнд асар их хүч өглөө. Зөвлөлтийн ард түмэн, гитлерийн цуст яргачидтай ширүүн тэмцэл хийж байгаа эх орны дайны хүнд өдрүүдэд болсон энэ уулзалт онцгой хүндтэй, онцгой гайхамшигтай бөгөөд энэ нь монгол ах дүү бидний сэтгэл зүрхэнд үүрд мартагдашгүй хоногших болно. Энэ уулзалт эрх чөлөөнд дуртай

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

бүх ард түмний анхаарал халамжийн дор Монгол-зөвлөлтийн ард түмний найрамдал хичнээн их өргөжиж байгааг дахин нотоллоо" /8/ гэжээ.

Олон түмний дунд зохион явуулах улс төр-соёл, гэгээрлийн ажил ч монгол, зөвлөлтийн ард түмний найрамдал, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэж байсан юм. Намын улс төрийн сургуулийн дээд шатанд Бүх Холбоотын Коммунист Большевикуудын намын түүхийг судалж, бүх чиглэлээр зөвлөлт эх орны дайны явцыг мэдээлж сурталчилж байв. Тухайлбал, 1943 онд Зөвлөлтийн ард түмний эх орны их дайн, зөвлөлтийн жангнуудын тухай 40-өөд товхимол, Розенталь, Александров болон бусад философичдын лекцийг монгол хэлээр орчуулан гаргажээ /9,356/. Мөн Улаанбаатар хотноо "Зөвлөлтийн ард түмний эх орны их дайн" сэдвээр үзэсгэлэн гаргаж байв. Монгол орны кино театр, клуб, улаан буланд гарч байсан кинонуудын их зонхийг зөвлөлтийн кино эзэлж байв. Зөвлөлтийн киног монгол хэлнээ орчуулан гаргах явдал эрс нэмэгджээ.

Зөвлөлт эх орны дайны жилүүд дэх Монгол-Зөвлөлтийн соёлын хамтын ажиллагаа нь:

1. Хоёр ард түмний үнэнхүү чин сэтгэл, хүндэтгэлийг илэрхийлсэн шинжтэй байв. Тэр үед Монголд ажиллаж байсан зөвлөлтийн сургагч, мэргэжилтнүүдийн сайхан сэтгэл, чин зүрхний туслалцааны тухай ахмад үе олон сонирхолтой дурсамж өгүүлдэг. Жишээ нь: МУИС-ийн ахмад ажилтан Я.Дэмбэрэл: МУИС-ийн анагаах ухааны факультетэд багшилж байсан нэгэн мэргэжилтэн багш Хандгайтад гөрөөлж яваад нэг айлд ортол шарх сорвиндоо баригдаж, хэвтэрт орсон нэгэн настай хүнтэй тааралдаж, түүний шархыг сорж, долоож цэвэрлээд эм цацаж өгсөн тухай дурсан ярьсан билээ. Энэ бол ганц л жишээ.

2. Энэ харилцаа агуулгын хувьд гүн гүнзгий, хэлбэрийн хувьд олон талтай байв. Өөр хэлбэл, агуулгын хувьд ах дүүсэг интернационалч шинжтэй, хэлбэрийн хувьд боловрол, шинжлэх ухаан, соёл, утга зохиол, урлагийн бүх салаа мөчрийг дүүрэн хамарч байлаа.

3. И.В.Сталин, Х.Чойбалсанг тахин шүтэх явдал газар авч байсны улмаас дайны үеийн монгол, зөвлөлтийн соёлын харилцаанд түүний хар сүүдэр ямар нэгэн хэмжээгээр тусаж байсан аж. Тухайлбал, монголчууд латин үсэг авах хөдөлгөөн өрнүүлж байгаад 1941 оноос кирилл үсэгт шилжиж эхэлсэн нь И.В.Сталины шахалт нөлөөтэй ямар нэгэн хэмжээгээр холбоотой байсан билээ. МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн 1941 оны IV сарын 25-ны өдрийн хамтарсан хурлын тогтоолд: "... тус

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

орны соёл боловсролын цаашдын хөгжилт нь гагцхүү ЗХУ-ын ард түмэнтэй ах дүү холбоог бэхжүүлэх, түүний баялаг соёлыг эзэмших замаар явах болно", "... Монгол бичгийг шинэ орос үсэг дээр шилжүүлэн авах явдал чухал хэмээн үзмүй" гэж тэмдэглээд, шинэ үсгийн дүрмийг зохиох комиссыг байгуулсан билээ.

4. Энэ үеийн хоёр орны соёлын харилцаа марксист-ленинист үзэл суртал, ангич байр сууринд тулгуурлан хөгжиж байсан нь нууц биш юм. Ийнхүү асуудалд ангичирхаж, хэт үзэл сурталжуулан хандаж байсны улмаас зарим нэг гажуудал ч гарч байжээ. 1944 оны V сард МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчоо "Намын гишүүн Б.Гонгоржаваас намын эсэргүү ба улс төрийн талаар дайсагнах явдал гаргасан тухай" тогтоол гаргажээ. Энэ тогтоолоор "үндэсний дээрэнгүй панмонголист" үзлийг баримталдаг, эх орны дайны үед ЗХУ, түүний армийн хүчинд үл итгэсэн, Монгол, Зөвлөлтийн найрамдалд дайсагнадаг, МАХН, ардын засгаас явуулж буй бодлогыг шүүмжилсэн үг яриа гаргадаг, 1930-аад оны үед баривчлагдсан "ардын дайсан" этгээдүүдийг илээр талархан сайшаадаг гэсэн хилс ялыг хүний их эмч, орчуулагч Б.Гонгоржавт тулган, түүнийг МАХН-аас хөөж, улмаар шийтгэсэн байна. Тус хурал дээр Ю.Цэдэнбал: "Бидний өмнө намын эсэргүү хүн зогсож байна. Энэ нь гадаадын дайсан, намын хүрээлэнд шургалж болохыг харуулж байна" /10.106/ гэж дүгнэжээ. Чөлөөт сэтгэлгээний аливаа илрэлийг намын эсрэг, зөвлөлтийн эсрэг хэмээн адлан дарах явдал даамжирч эхэлжээ

Монголын ард түмэн соёл болон бусад бүх салбарт зөвлөлтийн ард түмний тусламжийг хүртэн нөгөө талаар бололцоотой бүх зүйлээрээ Зөвлөлтөд тусалж байсан боловч сүүлдээ олон жил үргэлжилсэн дайнд залхаж, зарим нэг хүн сэтгэл алдрах, тэр ч байтугай дургүйцэх явдал мэр сэр гарсаар байсныг түүх-шинэчлэлийн үүднээс тэмдэглэх нь зүйд нийцнэ. Миний эцэг Ц.Жигжид (Болдбаатарын. Зох) 1944 онд Булган аймгийн намын хороонд зохиолын хэлтсийн туслахаар ажиллаж байхдаа Могод суманд томилолтоор очиход, хурал дээр нэг өвгөн: "Дарга аа, уруул, саруул хоёр нийлэхээ болиод гурав, дөрвөн жил боллоо, уур, нүдүүр нийлэхээ болиод бас гурав, дөрвөн жил боллоо. Нам, засаг биднийгээ яах гэж байна вэ?" хэмээн цөхөрсөн байдалтай асууж байжээ. Булган аймгийн Сайхан сумын харъяат "дэлчээ" хэмээх Лувсанжамц нэг хурал дээр: "Их орон, их орон, (Эх орон дайн гэж нэрлэснийг их болгон хэлж байна. Ж.Б) гээд л хамаг юмаа гадагш өгөөд байх юм, ингэсээр байтал бага орон чинь хэцүүдлээ шүү дээ" гэж хэлээд улс төрийн хэрэгт татагдан, шоронгийн хаалга татаж байсан гэдэг. Тэр үед зөвлөлтийн офицерууд ирж, адуунд мал эмнэлгийн

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

үзлэг хийж, (Малиндах гэж ярьдаг. Ж.Б), тэнцсэн бүх адууг маш хямд үнээр дайчлан худалдаж авч байсныг мөнөөх Лувсанжамц: “Оросын хоёр муу ёр (майор-хошууч. Ж.Б) ирээд хамаг морьдыг маань цөлмөөд явчихлаа” гэж ярьж яваад мөн шүүхэд дуудагдаж байсан аж. Энэ бүхэн нь дайнаас болж ард олон амьдрал доройтоод ирэхээр аргагүйдэн, тэдний дотор цөхрөл дургүйцэл газар авч эхэлсний илэрхийлэл, тэр үеийн монголын нийгэм-сэтгэл зүйн амьсгалын нэгээхэн хэсэг болж байв. Гэхдээ нийгэм-сэтгэл зүйн зарим нэг ийм сөрөг илэрхийлэл нь дэлхийн II дайны үеийн монгол, зөвлөлтийн соёлын харилцааны эерэг үр дүнг үгүйсгэж чадахгүй юм.

Эшлэл, зүүлт

1. Монгол Ардын Хувьсгалт Намын X их хурал. (Дэлгэрэнгүй тайлан). УБ., 1970
2. МУУТА. Ф-1, Т-2, хн-768
3. Н.Содном. Монгол Улсын университет . УБ. 2003
4. МУУТА. Ф-334, т-1, хн-162
5. МУИС-ийн архиваас
6. МУИС-ийн түүхийн товчоон. УБ., 2002
7. БНМАУ-ын соёлын түүх. /1941-1960/.Дэд боть.УБ., 1986
8. Бурятын үнэн. 1942.IX.20
9. Монгол-Зөвлөлтийн соёл шинжлэх ухаан, техникийн харилцаа /1921-1960/ УБ.8 2000
10. Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэн товчоон. УБ., 2001